



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хүрээ амаржих газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/175/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор	Г.Нандинжаргал
	Утас: 7000-7734	Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер	Х.Түвшинбаяр
	Утас: 327734	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	Я.Алтанцэцэг
	Утас: 315558	Цахим хаяг: altantsetseg.ya@audit.mn
	Б энд С аудит ХХК-ийн Захирал	Д.Заяажаргал
	Утас: 99050268	Цахим хаяг: info@bcauditllc.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 301
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХҮРЭЭ АМАРЖИХ
ГАЗРЫН ДАРГА Ш.АЛТАНТУЯА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хүрээ амаржих газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж, шалгагдагч байгууллагаас хараат бусаар ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын барилгыг сэргээн, иж бүрэн засварлах ажлын хүрээнд 45.5 тэрбум төгрөг, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт хийхэд 6.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Байгууллагын дэргэд ажилчдын хүүхдэд зориулсан цэцэрлэгийн зураг 283.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төслийг донор байгууллагуудад хүргүүлж, цэцэрлэгийн дотоод урсгал засварын ажил 150.1 сая төгрөгийн хандив дэмжлэгийг Тус-финанс ББСБ-тай хамтран ажиллахаар хүргүүлсэн байна.

1425050269

C:\Users\narangua\Desktop\Бичиг хэргийн хэргийн 2026\2026\word\yvaan bichig\2026.02.25 Dugneil - docx

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилго 5 зорилтын хүрээнд 78 арга хэмжээг 97.9 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u>	239,878,429.10	19,883,517.61
Төрийн сангийн харилцах	239,878,429.10	19,883,517.61
АВЛАГА	1,228,916.54	1,551,477,275.83
Ажиллагчидтай холбогдсон авлага		3,716,578.79
Татаас санхүүжилтийн авлага		1,526,583,780.50
Бусад авлага	1,228,916.54	21,176,916.54
БАРАА МАТЕРИАЛ	464,424,088.34	1,011,032,994.77
Эм боох материал	218,117,189.33	278,207,340.76
Хангамжийн материал	246,306,899.01	732,825,654.01
Бичиг хэрэг	5,727,500.50	9,804,229.00
Аж ахуйн материал	124,016,077.80	142,310,554.00
Сэлбэг хэрэгсэл		780,000.00
Түлш, шатах тослох материал	1,573,674.20	569,662.50
Бусад хангамжийн материал	114,989,646.51	579,361,208.51
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	705,531,433.98	2,582,393,788.21
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,085,137,336.22	54,811,181,612.16
Биет хөрөнгө	5,851,290,602.90	54,577,972,878.88
Барилга, байгууламж	1,475,030,624.60	46,961,174,057.60
Хуримтлагдсан элэгдэл	(870,024,295.44)	(908,675,500.92)
Авто- тээврийн хэрэгсэл	483,243,880.00	483,243,880.00
Хуримтлагдсан элэгдэл	(243,726,889.76)	(289,428,879.72)
Машин, тоног төхөөрөмж	8,611,544,205.81	12,650,921,820.81
Хуримтлагдсан элэгдэл	(3,895,615,094.48)	(5,233,907,967.69)
Тавилга, аж ахуйн эд хогшил	364,699,262.97	1,087,443,440.97
Хуримтлагдсан элэгдэл	(83,813,614.10)	(182,750,495.47)
Ном	9,952,523.30	9,952,523.30
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	233,846,733.32	233,208,733.28
Программ хангамж	3,990,000.00	3,990,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,012,666.68)	(1,650,666.72)
Бусад	230,869,400.00	230,869,400.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,085,137,336.22	54,811,181,612.16
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,790,668,770.20	57,393,575,400.37
Богино хугацаат өр төлбөр		
Өглөг	778,010,445.03	873,714,940.75
Ажиллагчидтай холбогдсон өглөг		601,501,022.48
Бараа үйлчилгээний зардлын өглөг	453,560,457.77	272,213,918.27
Татаас, санхүүжилтийн өглөг	324,449,987.26	
Бусад өглөг	-	166,478,730.00
Байгууллагад төлөх өглөг		166,478,730.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	778,010,445.03	1,040,193,670.75
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	778,010,445.03	1,040,193,670.75
Засгийн газрын хувь оролцоо	6,012,658,325.17	56,353,381,729.62
Засгийн газрын оруулсан капитал	2,195,199,872.60	2,195,199,872.60
- төрийн	2,195,199,872.60	2,195,199,872.60
Дахин үнэлгээний нэмэгдэл	482,547,172.60	482,547,172.60
Хуримтлагдсан үр дүн	3,334,911,279.97	53,675,634,684.42
Өмнөх үеийн үр дүн		3,334,911,279.97
Тайлан үеийн үр дүн		50,340,723,404.45
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	6,012,658,325.17	56,353,381,729.62
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	6,790,668,770.20	57,393,575,400.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
<u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	641,609,242.74	10,473,579,841.70
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	10,214,331,421.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		10,214,331,421.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	641,609,242.74	259,248,420.70
ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,670,100.00	
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	522,939,142.74	259,248,420.70
Бараа, үйлчилгээний орлого	8,888,900,694.30	51,266,855,941.72
Төсөвт байгууллагын өөрийн орлого	173,578,971.88	503,087,135.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,070,380.88	424,096,216.00
Туслах үйл ажиллагааны орлого	15,508,591.00	78,990,919.00
Төлбөртэй шинжилгээ	42,044,040.88	233,604,974.00
Төлбөртэй өрөө	79,226,340.00	151,181,242.00
Үр хөндөлт	36,800,000.00	39,310,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	1,389,643,656.06	50,248,265,226.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	133,174,781.36	515,503,580.72
Тусламжийн орлого	7,192,503,285.00	-
Хандив тусламж /дотоод/	7,192,503,285.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,530,509,937.04	61,740,435,783.42
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
<u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>	6,353,078,419.67	7,675,592,008.43
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,552,391,205.80	6,829,610,271.65
Цалин	2,631,115,977.79	3,391,214,168.38
Цалингийн тусгай нэмэгдлүүд	2,005,364,243.28	2,710,207,443.24
Унаа хоолны хөнгөлөлт	281,538,178.33	284,521,060.82
Урамшуулал	634,372,806.40	443,667,599.21
Нийгмийн хамгааллын шимтгэл	800,687,213.87	845,981,736.78
Тэтгэврийн даатгал	598,509,798.90	577,395,703.77
Тэтгэмжийн даатгал	51,196,100.00	69,898,842.25
ҮОМШӨ-ний даатгал	25,598,000.00	46,177,687.89
Эрүүл мэндийн даатгал	99,785,314.97	122,153,520.81
Ажилгүйдлын даатгал	25,598,000.00	30,355,982.06
<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u>	2,710,181,792.87	3,619,439,441.65
Тогтмол зардал	143,128,069.75	-
Гэрэл цахилгааны зардал	62,534,667.49	
Түлш, халаалтын зардал	23,280,722.11	
Цэвэр, бохир усны зардал	57,312,680.15	
Үйл ажиллагааны зардал	1,470,118,943.05	1,736,725,867.53
Эм	1,203,607,943.05	1,383,345,867.53
Хоол	266,511,000.00	353,380,000.00
Бусад бараа үйлчилгээний зардал	1,096,934,780.07	1,882,713,574.12
Бичиг хэргийн материал	7,958,867.00	1,224,020.00

Тээвэр, шатахууны зардал	6,997,375.80	6,915,611.70
Шуудан холбооны зардал	6,960,126.00	26,652,401.00
Хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,363,434.50	26,268,070.00
БҮТЭЭ	39,736,334.00	7,946,656.00
Бараа материал акталсны зардал	107,463,354.23	3,588,536.06
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	27,827,650.00	332,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4,644,277.00	7,033,292.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	49,393,490.00	61,485,308.80
Банкны үйлчилгээний хураамж	147,000.00	
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	29,532,281.00	165,743,884.00
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	
Даатгалын үйлчилгээ	542,320.00	503,172.00
Тээврийн хэрэгслийн татвар	490,688.00	1,213,536.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	123,439.00	
Маягт хэвлүүлэх зардал	8,758,778.50	21,701,746.50
Багаж, техник, хэрэгсэл		3,175,000.00
Урсгал засварын зардал	2,664,000.00	17,240,900.00
Тавилга	460,000.00	
Газрын төлбөр	2,694,080.00	1,767,990.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ		7,700,000.00
Элэгдлийн зардал	747,177,285.04	1,522,220,950.06
Урсгал шилжүүлэг	169,165,399.00	104,680,928.89
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	156,517,400.00	99,644,288.89
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	12,647,999.00	5,036,640.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	9,232,425,611.54	11,399,712,378.97
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	298,084,325.50	50,340,723,404.45
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	298,084,325.50	50,340,723,404.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого	8,415,025,363.88	8,363,297,653.24
Нийгмийн даатгалын сангаас	7,580,105,852.24	8,363,297,653.24
Эрүүл мэндийн даатгалын сангаас	7,580,105,852.26	8,363,297,653.24
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	259,248,420.70
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан		259,248,420.70
Бараа, үйлчилгээний орлого	834,919,511.62	483,210,135.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	174,127,917.88	424,096,216.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,791,593.74	59,113,919
Төлбөртэй шинжилгээ	180,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,250,124,875.50	9,105,756,208.94
Ажиллагчидтай холбогдсон зардал	6,353,078,419.67	7,076,885,664.74
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,552,959,319.34	6,321,606,403.25
Цалин	2,533,115,977.82	2,897,808,115.51

Цалингийн тусгай нэмэгдлүүд	2,015,711,641.79	2,645,650,404.95
Унаа хоолны хөнгөлөлт	281,538,179.33	332,616,034.55
Урамшуулал	722,593,520.40	445,531,848.24
Нийгмийн хамгааллын шимтгэл	800,119,100.33	755,279,261.49
Тэтгэврийн даатгал	598,508,799.46	510,534,261.49
Тэтгэмжийн даатгал	51,196,100.00	61,186,300.00
ҮОМШӨ-ний даатгал	25,598,000.00	30,593,100.00
Ажилгүйдлийн даатгал	25,598,000.00	30,593,100.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	99,218,200.87	122,372,500.00
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	1,467,049,697.98	2,144,012,626.80
Тогтмол зардал	162,949,366.75	-
Гэрэл цахилгааны зардал	82,265,964.49	
Түлш, халаалтын зардал	23,280,722.11	
Цэвэр, бохир усны зардал	57,402,680.15	
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	1,075,158,452.43	1,942,175,156.80
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	808,647,452.43	1,588,795,156.80
Хоол, хүнс	266,511,000.00	353,380,000.00
Бусад бараа үйлчилгээний зардал	228,941,878.80	201,837,470.00
Бичиг хэргийн материал	15,710,495.00	17,399,045.00
Тээвэр, шатахууны зардал	7,700,000.00	5,911,600.00
Шуудан холбооны зардал	6,960,126.00	26,652,401.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,290,731.00	21,878,000.00
БҮТЭЗ	32,312,750.00	31,595,250.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	32,328,700.00	653,900.00
Бараа үйлчилгээний бусад зардал	27,369,505.00	7,871,292.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	11,223,895.80	10,125,000.00
Банкны үйлчилгээний хураамж	147,000.00	
Маягт хэвлүүлэх зардал	1,478,950.00	389,500.00
Багаж техник хэрэгсэл	9,149,250.00	9,996,000.00
Тавилга	1,459,300.00	
Урсгал засварын зардал	10,606,700.00	19,086,900.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,353,949.00	39,093,884.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	
Даатгалын үйлчилгээ	542,320.00	503,172.00
Тээврийн хэрэгслийн татвар	490,688.00	1,213,536.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	123,439.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		7,700,000.00
Газрын төлбөр	2,694,080.00	1,767,990.00
Урсгал шилжүүлэг	169,017,399.00	104,852,828.89
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	156,517,400.00	99,644,288.89
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	12,499,999.00	5,208,540.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	7,989,145,516.65	9,325,751,120.43
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,260,979,358.85	(219,994,911.49)
Хөрөнгийн орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)	-	-

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	-	-
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
Валютын ханшийн зөрүү		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	1,260,979,358.85	(219,994,911.49)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		239,878,429.10
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	239,878,429.10	19,883,517.61

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,195,199,872.60	495,007,367.90	3,024,366,759.17	5,714,573,999.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			12,460,195.30	12,460,195.30
Залруулсан үлдэгдэл	2,195,199,872.60	495,007,367.90	3,036,826,954.47	5,727,034,194.97
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(12,460,195.30)		(12,460,195.30)
Зарласан ногдол ашиг			298,084,325.50	298,084,325.50
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,195,199,872.60	482,547,172.60	3,334,911,279.97	6,012,658,325.17
Залруулсан үлдэгдэл	2,195,199,872.60	482,547,172.60	3,334,911,279.97	6,012,658,325.17
Тайлант үеийн үр дүн			50,340,723,404.45	50,340,723,404.45
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,195,199,872.60	482,547,172.60	53,675,634,684.42	56,353,381,729.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	8,506,856,300.00	8,363,297,653.24	143,558,646.76	98.3
Нийгмийн даатгалын сангаас	8,506,856,300.00	8,363,297,653.24	143,558,646.76	98.3
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,506,856,300.00	8,363,297,653.24	143,558,646.76	98.3
Бараа, үйлчилгээний орлого	776,042,400.00	42,458,555.70	33,583,844.30	95.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,164,000.00	24,096,216.00	35,067,784.00	92.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	316,878,400.00	318,362,339.70	(1,483,939.70)	100.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,282,898,700.00	9,105,756,208.94	177,142,491.06	98.1
Ажиллагчидтай холбогдсон зардал	7,169,652,500.00	7,076,885,664.74	92,766,835.26	98.7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	6,401,170,400.00	6,321,606,403.25	79,563,996.75	98.8
Цалин	3,198,492,500.00	2,897,808,115.51	300,684,384.49	90.6
Цалингийн тусгай нэмэгдлүүд	2,023,356,400.00	2,645,650,404.95	(622,294,004.95)	130.8
Унаа хоолны хөнгөлөлт	538,982,500.00	332,616,034.55	206,366,465.45	61.7
Урамшуулал	640,339,000.00	445,531,848.24	194,807,151.76	69.6
Нийгмийн хамгааллын шимтгэл	768,482,100.00	755,279,261.49	13,202,838.51	98.3
Тэтгэврийн даатгал	523,737,100.00	510,534,261.49	13,202,838.51	97.5
Тэтгэмжийн даатгал	61,186,300.00	61,186,300.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	30,593,100.00	30,593,100.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	30,593,100.00	30,593,100.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгалын хураамж	122,372,500.00	122,372,500.00	-	100.0
Бараа, үйлчилгээний урсгал зардал	2,180,724,200.00	2,144,012,626.80	36,711,573.20	98.3
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	1,956,407,200.00	,942,175,156.80	14,232,043.20	99.3
Эм	1,622,653,900.00	1,588,795,156.80	33,858,743.20	97.9
Хоол	333,753,300.00	353,380,000.00	(19,626,700.00)	105.9
Бусад бараа үйлчилгээний зардал	224,317,000.00	201,837,470.00	22,479,530.00	90.0
Бичиг хэргийн материал	21,500,000.00	17,399,045.00	4,100,955.00	80.9
Тээвэр, шатахууны зардал	7,333,600.00	5,911,600.00	1,422,000.00	80.6
Шуудан холбооны зардал	20,617,000.00	26,652,401.00	(6,035,401.00)	129.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,667,000.00	21,878,000.00	3,789,000.00	85.2
БҮТЭЭ	36,900,000.00	31,595,250.00	5,304,750.00	85.6
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,000,000.00	653,900.00	1,346,100.00	32.7
Бараа үйлчилгээний бусад зардал	7,923,400.00	7,871,292.00	52,108.00	99.3
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	12,250,000.00	10,125,000.00	2,125,000.00	82.7
Банкны үйлчилгээний хураамж	200,000.00		200,000.00	-
Маягт хэвлүүлэх зардал	4,000,000.00	389,500.00	3,610,500.00	9.7
Багаж, техник хэрэгсэл	11,800,000.00	9,996,000.00	1,804,000.00	84.7

Урсгал засварын зардал	20,500,000.00	19,086,900.00	1,413,100.00	93.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,768,000.00	1,767,990.00	10.00	100.0
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	41,250,000.00	39,093,884.00	2,156,116.00	94.8
Даатгалын үйлчилгээ	600,000.00	503,172.00	96,828.00	83.9
Тээврийн хэрэгслийн татвар	1,229,000.00	1,213,536.00	15,464.00	98.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	279,000.00		279,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,500,000.00	7,700,000.00	800,000.00	90.6
Урсгал зардлын дүн	171,779,600.00	104,852,828.89	66,926,771.11	61.0
Бусад урсгал шилжүүлэг	171,779,600.00	104,852,828.89	66,926,771.11	61.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	159,279,600.00	99,644,288.89	59,635,311.11	62.6
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	12,500,000.00	5,208,540.00	7,291,460.00	41.7
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	9,522,156,300.00	9,325,751,120.43	196,405,179.57	97.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		239,878,429.10	(239,878,429.10)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		19,883,517.61	(19,883,517.61)	

ТОДРУУЛГА 5. АВЛАГА

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Эцсийн үлдэгдэл
1	Ажилчидтай холбогдсон авлага		223,684,803.45	219,968,224.66	3,716,578.79
2	Татаас санхүүжилтийн авлага		9,889,881,433.74	8,363,297,653.24	1,526,583,780.50
3	Байрны түрээсийн авлага		64,296,973.00	44,419,973.00	19,877,000.00
4	Эмийн авлага		71,000.00		71,000.00
5	Байгууллагаас авах авлага	1,228,916.54	190,163,956.00	190,163,956.00	1,228,916.54
6	Хүмүүстэй хийх тооцооны авлага		1,536,000.00	1,536,000.00	
7	Дүн	1,228,916.54	10,369,634,166.19	8,819,385,806.90	1,551,477,275.83

ТОДРУУЛГА 8. ӨГЛӨГ

№		Өмнөх он	Нэмэгдсэн	Хорогдсон	Тайлант он
1	Ажилчидтай холбогдсон өглөг		8,714,092,088.60	8,112,591,066.12	601,501,022.48
2	Эмийн өглөг	453,560,457.77	1,406,065,617.30	1,587,412,156.80	272,213,918.27
3	Татаас санхүүжилтийн өглөг	324,449,987.26		324,449,987.26	-
4	Байгууллагад төлөх өглөг		375,318,402.00	208,839,672.00	166,478,730.00
5	Хүмүүстэй хийх тооцооны өглөг		171,856,618.89	171,856,618.89	-
6	Дүн	778,010,445.03	10,667,332,726.79	10,405,149,501.07	1,040,193,670.75

ТОДРУУЛГА 6. БАРАА МАТЕРИАЛ

№		Эм боох материал	Бичиг хэргийн материал	Аж ахуйн материал	Сэлбэг хэрэгсэл	Түлш, шатах тослох материал	Бусад хангамжийн материал	Нийт дүн
1	Оны эхний үлдэгдэл	218,117,189.33	5,727,500.50	124,016,077.80		1,573,674.20	114,989,646.51	464,424,088.34
2	Нэмэгдсэн	1,445,789,555.02	25,700,475.00	85,339,855.00	9,791,400.00	5,911,600.00	471,585,868.00	2,044,118,753.02
3	Худалдан авсан	1,406,144,617.30	25,700,475.00	66,343,680.00	9,791,400.00	5,911,600.00	14,723,400.00	1,528,615,172.30
4	Хандиваар	39,644,937.72		18,996,175.00			456,862,468.00	515,503,580.72
7	Хасагдсан	1,385,699,403.59	21,623,746.50	67,045,378.80	9,011,400.00	6,915,611.70	7,214,306.00	1,497,509,846.59
8	Худалдсан, зарцуулсан	1,382,110,867.53	21,623,746.50	67,045,378.80	9,011,400.00	6,915,611.70	7,214,306.00	1,493,921,310.53
10	Бусад	3,588,536.06						3,588,536.06
11	Эцсийн үлдэгдэл	278,207,340.76	9,804,229.00	142,310,554.00	780,000.00	569,662.50	579,361,208.51	1,011,032,994.77

ТОДРУУЛГА 7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

№	Үзүүлэлт	Барилга	Авто тээврийн хэрэгсэл	Тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Программ хангамж	Номын фонд	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/								
1.1	Эхний үлдэгдэл	1,475,030,624.60	483,243,880.00	8,611,544,205.81	364,699,262.97	3,990,000.00	9,952,523.30	230,869,400.00	11,179,329,896.68
1.2	Нэмэгдсэн дүн	45,486,143,433.00	-	4,039,377,615.00	722,744,178.00	-	-	-	50,248,265,226.00
1.2.2	Хандиваар авсан	45,486,143,433.00		4,039,377,615.00	722,744,178.00				50,248,265,226.00
1.6	Эцсийн үлдэгдэл	46,961,174,057.60	483,243,880.00	12,650,921,820.81	1,087,443,440.97	3,990,000.00	9,952,523.30	230,869,400.00	61,427,595,122.68
2	ХУРИМТЛ АГДСАН ЭЛЭГДЭЛ								-

2.1	Эхний үлдэгдэл	870,024,295.44	243,726,889.76	3,895,615,094.48	83,813,614.10	1,012,666.68			5,094,192,560.46
2.2	Нэмэгдсэн дүн	38,651,205.48	45,701,989.96	1,338,292,873.21	98,936,881.37	638,000.04	-	-	1,522,220,950.06
2.2. 1	Байгуулс ан элэгдэл	38,651,205.48	45,701,989.96	1,338,292,873.21	98,936,881.37	638,000.04			1,522,220,950.06
2.4	Эцсийн үлдэгдэл	908,675,500.92	289,428,879.72	5,233,907,967.69	182,750,495.47	1,650,666.72	-	-	6,616,413,510.52
3	ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН								-
3.1	Эхний үлдэгдэл								-
3.2	Эцсийн үлдэгдэл	46,052,498,556.68	193,815,000.28	7,417,013,853.12	904,692,945.50	2,339,333.28	9,952,523.30	230,869,400.00	54,811,181,612.16

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,996,859.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эмийн няравын тайлангийн зарлага бараа материалын дэлгэрэнгүй тайлантай зөрүүтэй	1	42,700.8			1	42,700.8						
Үндсэн хөрөнгийн тайланд шинэ барилга орлогод аваагүй	1	45,472,643.4	1	45,472,643.4								
Үнэ төлбөргүй ирсэн болон худалдан авсан эм орлогод аваагүй	1	7,997.7	1	7,997.7								
Зогсоол, цайны газрын түрээсийн орлогийн үлдэгдэлд авлага үүсгээгүй	1	22,975.6	1	22,975.6								
Мөнгөн гүйлгээний тайлан дээр орлого дутуу тайлагнасан	1	235,656.5	1	235,656.5								
Цалингийн бичилт буруу хийснээс ОУДТ дээр ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 592,197.0 мянган төгрөг, цалингийн зардал 622,688.2 мянган төгрөгийг тус тус дутуу тайлагнасан	1	1,214,885.2			1	1,214,885.2						
Дүн	6	46,996,859.3	4	45,739,273.1	2	1,257,586.0						

Аудитаар нийт 29,497.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 29,381.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 115.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах Албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагын үлдэгдэл 19,731.9 мянган төгрөгийг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	19,731.9			1	19,731.9						
Өглөгийн үлдэгдэл 9,650.0 мянган төгрөгийг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	9,650.0			1	9,650.0						
Санхүүгийн тайлан дах бараа материалын үлдэгдэл, бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдлээс 115.5 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байна.	1	115.5					1	115.5				
Дүн	3	29,497.4			2	29,381.9	1	115.5				

Нийцлийн асуудлаар илэрсэн 222,046.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 222,046.1 мянган төгрөгийн 17 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	222,046.1			1	222,046.1		
Дүн	1	222,046.1			1	222,046.1		

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.